

ТАНИЛЦУУЛГА

“Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл”-ийн тухай

1. Төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

Монгол Улс Логистикийн гүйцэтгэлийн индексийн үзүүлэлтээр Дэлхийн 160 орноос 130 дугаар байранд байгаа нь Монгол Улсын тээвэр, логистикийн салбарыг хөгжүүлэх зайлшгүй шаардлага үүссэнийг харуулж байна. Мөн хөдөө, аж ахуйн бүтээгдэхүүн, түүний дотор мах, махан бүтээгдэхүүний эцсийн хэрэглэгчид хүрч буй нийт өртгийн 30 орчим хувийг тээвэр, логистикийн зардал эзэлж байна.

Монгол Улсын урт хугацааны “Алсын хараа 2050” хөгжлийн бодлогын 2021-2030 оны үр дүнгийн 4-т “Олон улсын болон бүсийн тээвэр логистикийн нэгдсэн сүлжээг үе шаттай барьж байгуулж, хөрш орнуудын сүлжээтэй холбогдсон байна.” гэж заасан.

Иймд махны төрөлжсөн логистикийг хөгжүүлж, авто замын сүлжээний бэлэн байдлыг сайжруулан, логистикийн тогтолцоог бүрдүүлснээр эцсийн хэрэглэгчид шинэ, сайн чанарын мах, махан бүтээгдэхүүнээр хангаж, мах, махан бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, хэрэглэгчид очих махны өртгийг бууруулахад төслийн зорилго оршино.

“Монгол Улсын тээвэр логистикийг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлснээр уул уурхайн салбарын үйл ажиллагаанаас ихээхэн хамааралтай эдийн засгийг төрөлжүүлэх, тээвэр, логистикийн дэд бүтцийн сүлжээг сайжруулан, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээний алдагдлыг бууруулах ач холбогдолтой юм.

“Монгол Улсын тээвэр логистикийг сайжруулах төсөл” нь дараах үндсэн 3 бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Үүнд:

1.1. Жишиг логистикийн төв

Техник, эдийн засгийн үндэслэлээр зорилтот 8 аймгийг мах, махан бүтээгдэхүүний тээврийн урсгал, малын тоо, толгой, газарзүйн байршил зэргээс хамааруулан махны чанарыг алдагдуулахгүй нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх нөхцөлийг хангасан логистикийн жишиг төвийн эдийн засгийн үр өгөөжийг тооцон Өвөрхангай аймагт байгуулахаар төлөвлөөд байна. Жишиг логистикийн төвийг байгуулах ажлыг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх бөгөөд дараах ажлуудыг хийхээр төлөвлөсөн. Үүнд:

- Бүсийн хүрээнд тусгай горим шаардах мах, махан бүтээгдэхүүний төрөлжсөн жишиг логистикийн төв, дэд бүтцийг бий болгох (авто зам, зогсоол, талбай, цахилгаан, цэвэр ус, ариутгах татуурга);
- Орчин үеийн дэвшилтэт технологи болох блокчэйн, Радио давтамжийн илрүүлэлт /RFID/ технологиудыг ашиглан үндэсний логистикийн платформ

байгуулах, үйлчилгээг нэг цэгээс хэрэглэгчийн гарт хүрэх бүх дамжлагыг цахимаар хянах боломжийг бүрдүүлэх юм.

1.2. Ээлжит болон их засвар хийх зам, гүүр

Дээрх жишиг логистикийн төвийн тээвэрлэлтийн нэгдсэн сүлжээтэй холбогдох холболтыг үндэслэн авто замын чиглэлийг сонгосон. Төслийн хүрээнд улсын чанартай 311 км авто зам, 8ш төмөр бетон гүүрэнд их засвар болон ээлжит засвар хийх бөгөөд авто замын ашиглалтын түвшин, насжилт, тэгш байдлын индекс, хөдөлгөөний эрчим зэргийг харгалзан эдгээр зам, гүүрийг сонгосон.

Хүснэгт 1: Ээлжит болон их засвар хийх замын чиглэл

№	Авто зам	Ээлжит засвар хийх авто замын хэсэг (км)	Шинэчлэлт хийх авто замын хэсэг (км)
1	Улаанбаатар-Арвайхээр	72	33
2	Улаанбаатар-Өндөрхаан	-	68
3	Хархорин-Цэцэрлэг	13	27
4	Булган-Мөрөн	-	13
5	Цэцэрлэг-Тосонцэнгэл (Архангай)	40	10
6	Арвайхээр-Баянхонгор (Өвөрхангай)	-	35
7	8 гүүрийн засварын ажил		
	Нийт	125 км	186 км

1.3. Шинээр барих авто зам

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Нутгийн зам” хөтөлбөрийн зорилтот найман аймгийн холбогдох сумдаас Дэлхийн банкны аргачлалын дагуу шалгуур үзүүлэлтүүдийн үр дүнгээр сонгож, Архангай аймгийн Булган сум- 35км, Өвөрхангай аймгийн Есөнзүйл сум-16 км, нийт 51 км хатуу хучилттай авто замыг шинээр барина.

1.4. Техник туслалцаа

Замын сүлжээний хөрөнгийн менежментийг боловсронгуй болгох, хууль эрх зүйн орчныг сайжруулах, дэвшилтэт программ хангамж нэвтрүүлэх, боловсон хүчнийг чадавхжуулах стандарт, норм нормативыг сайжруулах, шинэчлэхэд чиглэгдэх юм.

2. Төслийн зээлийн хэмжээ, нөхцөл, хамрах хугацаа

Төсөл хэрэгжүүлэгч: Зам, тээврийн хөгжлийн яам

Төсөл хэрэгжих хугацаа: 2022 он – 2025 он /4 жил/

“Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл” нь нийт 132¹² сая ам.долларын төсөвт өртөгтэй бөгөөд Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк (ОУСБХБ)-аас олгох 100 сая ам. доллар хөнгөлөлттэй зээл, Олон улсын хөгжлийн ассоциаци (ОУХА)-аас олгох 7.3 сая зээлжих тусгай эрх бүхий

¹ Монголын талын 2 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар Замын сүлжээний хөрөнгийн менежментийг боловсронгуй болгох, хууль эрх зүйн орчныг сайжруулах, дэвшилтэт программ хангамж нэвтрүүлэх, боловсон хүчнийг чадавхжуулах стандарт, норм нормативыг сайжруулах, шинэчлэхэд юм.

² Тээвэр ба логистикийн үйлчилгээний 20 сая ам. долларыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд тус хөрөнгө оруулалтаар жишиг логистикийн төвийг байгуулахад чиглүүлэх юм.

нэн хөнгөлөлттэй зээлүүдээс бүрдэх ба жилийн Баталгаат овернайт хүүгийн түвшин /SOFR/³ дээр 1.30 хувийн нэмэгдэл бүхий хувьсах хүүтэй, 5 жилийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх, 30 жилийн хугацаанд зээлийн эргэн төлөлтийг хийх нөхцөлтэй болно. Доорх хүснэгтээр төслийн санхүүжилтийн задаргааг харуулав. Үүнд:

Хүснэгт 2: Зээлийн хөрөнгийн задаргаа:

/сая ам. доллар/

№	Хийгдэх ажил	Дүн (сая ам. доллар)	Зарцуулах хувь
1	Дэд бүтцийн хөрөнгө оруулалт	80	72.7%
2	Тээвэр ба логиستيкийн үйлчилгээ	28	25.4%
3	Техник туслалцаа	2	1.9%
Нийт дүн		110	100%

3. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцсэн байдал

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.3-т заасны дагуу Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа нь 2022 онд 70 хувь, 2023 онд 65 хувь, 2024 оноос эхлэн 60 хувиас хэтрэхгүй байхаар тус тус хуульчлагдсан.

Энэ хүрээнд 2022-2025 оны хооронд эдийн засаг харгалзан 2.8 хувь, 4.5 хувь, 5.1 хувь, 6.14 хувиар өсөж, Монгол Улсын 2022 оны батлагдсан төсөв, 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн төсөөлөлд тусгагдсан гадаад зээлийн хөрөнгийг авч ашиглах тохиолдолд өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь 2022 онд 56.6 хувь, 2023 онд 53.2 хувь, 2024 онд 51.7 хувьтай тус тус тэнцэхээр тооцоологдсон. Ингэснээр эдгээр онуудад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг хангахаар байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

³ Secured Overnight Financing Rate буюу баталгаат овернайт санхүүжилтийн хүү.

⁴ Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах үеийн тооцоолол.